



Г МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бөхчүүлүн ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-30-34, Факс: 26-30-34
E-mail: purevdorj@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.10.21 № ЧИЛ-03/9854
танай _____ -ны № _____ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хүрээнд Төмөр замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн тогтоолын төслийг боловсрууллаа. Иймд уг хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.ПҮРЭВДОРЖ



Г УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бөхчүлүүны ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-30-34, Факс: 26-30-34
E-mail: purevdorj@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022. 06. 15 № УИХ-03/5945

танай _____ -ны № _____ -т

Г Тов тогтоолгох тухай Т

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдуулан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсныг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 21 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ

000357

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ


“Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 7.1.2-т зааснаар Ковидын дараах эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хямралтыг даван туулах зорилгыг хэрэгжүүлэхээр Төмөр замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос хилийн боомт хүрэх ачаа тээврийн зориулалттай төмөр замын шугамын цариг нь импортлогч оронд тавигдсан царигтай тохирч байхаар бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж, ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л. Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

БАТЛАВ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.ПУРЭВДОРЖ

**“ТӨРӨЕС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Хуульзүйн үндэслэл

“Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 7.1.2-т зааснаар Ковидын дараах эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хямралтыг даван туулах зорилгыг хэрэгжүүлэхээр Төмөр замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 заалтыг тус тус үндэслэн боловсруулсан болно.

1.2 Практик шаардлага

Ковидын дараах эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хямралтыг даван туулах шаардлага дэлхийн улс орнуудад тулгарч байна. Монгол улсын эдийн засгийн бүтэц нь уул уурхайгаас хамааралтай хэвээр байгаа бөгөөд энэ байдал ойрын жилүүдэд өөрчлөгдөхгүй юм. Эдийн засгaa солонгоруулахын тулд бусад салбарт оруулах хөрөнгө оруулалт чухал юм. Ийм боломжийг Монгол улсын экспортын бүтээгдэхүүнийг бага зардлаар уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа энэ цаг хугацаанд хийх ёстой. Иймээс төмөр замын шинэ шугам баригдаж ашиглалтад орсноор төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй систем бүрдэж эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн хамт дамжин өнгөрөх тээвэр илүү хөгжих ажлын байр шинээр нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.

Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий нүүрс болон бусад ашигт малтмалын ордууд ашиглалтад орсноор экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар өнөөдөр ашиглаж буйгаас 3.5 дахин нэмэгдэх тойм тооцоо байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд төмөр замын тээн нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах

тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн

Далайд гарцгүй Монгол Улсын хувьд хөрш орнууддаа, цаашлаад тэдгээрээр дамжин далайд хүрч гуравдагч улсуудад бараа, бүтээгдэхүүнээ ашигтай нэхцөлөөр экспортлохын тулд зөвхөн төмөр замын дотоодын оновчтой зохион байгуулалт бүхий нэгдсэн сүлжээтэй болохоос гадна төмөр замаар хөрш улсуудын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын бүтээн байгуулалтын дунд ОХУ болон БНХАУ-ын төмөр замуудтай холбогдох шинэ гарц нээгдэнэ.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос хилийн боомт хүрэх ачаа тээвэрлэлтийн зориулалттай төмөр замын шугамын царигийн өргөнийг Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхээр заасан байдаг.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгасан болно. Үүнд:

1 дүгээр зүйлд: Экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос хилийн боомт хүрэх ачаа тээврийн зориулалттай төмөр замын шугамын цариг нь импортлогч оронд тавигдсан царигтай тохирч байхаар;

2 дугаар зүйлд: “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тус тус тусгасан.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна:

1. Ковидын дараахь эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хямралыг ард иргэдийн амьдралд хүндрэл багатайгаар даван туулах боломж нээгдэх юм.
2. Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын төмөр замын салбарын хамтын ажиллагаа эрчимжиж уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт, тээвэрлэлтийн зардал, хугацаа хэмнэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тогтвортой өсөн нэмэгдсэнээр төсвийн орлого тогтворжиж, эдийн засагт эерэг үр дагавар үзүүлнэ.

3. Дээрх төмөр замын шинэ шугам баригдаж ашиглалтад орсноор төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй систем бүрдэж эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн хамт дамжин өнгөрөх тээвэр илүү хөгжих нөхцөл бүрдэнэ.
4. Тус төмөр замын бүтцийг дагасан хот, суурин, боловсруулах үйлдвэрүүд бий болох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдэн ажлын байр шинээр нэмэгдэж, хүн амын амьжирааны түвшин дээшилж, амьдрах орчин, нөхцөл сайжирснаар төв рүү чиглэсэн хүн амын нүүдэл саарна.
5. Далайд гарцгүй манай улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа өргөжиж, уул уурхайн бүтээгдэхүүнийг хөрш орнууд болон гуравдагч орнуудад экспортлох боломж бүрдэнэ.
6. Дэлхий нийтийг хамарсан цар тахал болон бусад геополитик, эдийн засгийн хямрал нүүрлэсэн өнөө үед хүнээс хамаарал багатай их хэмжээний тээвэр хийх боломжийг гаргаснаар экспортын орлого нэмэгдэнэ.
7. Алдагсан боломжоо нөхөх шийдэл бий болно. Манай улсын уул уурхайн экспортын хамгийн голлох бүтээгдэхүүн болох коксжих нүүрс, зэсийн 50 орчим хувийг Тавантолгой - Гашуунсухайтын боомт дангаараа гаргадаг. Хэрэв элдэв улс төргүйгээр 2013 онд төмөр зам тавьсан бол өдгөө нийт 375 сая тонн эрдэс бүтээгдэхүүн экспортолж хамгийн багаар бодоход 80 их наяд төгрөгийн орлого олж Монгол улсын эдийн засаг хоёроос гурав дахин томрох, аж ахуй нэгжүүд, ажлын байр нэмэгдэх, ядуурал огцом буурах, Ковидын хүндрэлийг элдэв дарамтугийгээр даван туулах, Монгол улсын Засгийн газрын өрийг 20 орчим хувьд барих боломж алдагджээ.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд, Улсын Их Хурлын холбогдох тогтоолуудтай нийцсэн болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын хуулиуд болон Улсын Их хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт орохгүй болно.

--- оОо ---

**“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН**

ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын эдийн засаг 2020 онд 5.3 хувиар огцом буурч, 2021 онд дөнгөж 1.4 хувь өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, манай улсын эдийн засаг сүүлийн хоёр жил агшжээ. Энэ оны эхны улиралын дүн ч нэн тааруу буюу хасах 3.8 хувьтай гарчээ. Инфляць буюу үнийн өсөлт 15 хувь хүрсэн нь Ази тивдээ Шри-Ланкийн дараа орох үзүүлэлт юм. Эдийн засаг нь агшаад зогсохгүй өндөр инфляцтай давхцах үзэгдлийг эдийн засагт стагфляц гэдэг. Тэгвэл Монгол улс стагфляцид нэрвэгдээд зогсохгүй нэмээд өрийн хямралд өртжээ. Ийм гурвалсан хямралыг даван туулах туйлын хүнд. Манай улс 3.4 сая хүн амтай, ДНБ нь ердөө 13 тэрбум ам.доллар хэрнээ нийт өр 33 тэрбум ам.доллар давжээ. Энэ нь нэг хүнд оногдох өрийн хэмжээгээр дэлхийд тэргүүлэх үзүүлэлт юм.

ОУВС, Дэлхийн банк, Азийн Хөгжлийн банкнаас Монгол улс халамжийн элдэв хөтөлбөрүүдээ зогсоож, өрийн асуудалдаа анхаарах, инфляциа цаашид өсгөхгүй байх, стагфляциас гарах төлөвлөгөө гаргах ёстой гэдгийг сануулж байгаа. Мөн эдгээр байгууллагууд манай улсын эдийн засгийн бодит өсөлт 2022 оны хувьд 1 орчим хувьд байх тооцоолол хийжээ. Дэлхийн банк “Украины дайнаас шалтгаалан түлш, шатахууны үнэ өндөр түвшинд хадгалагдаж, дэлхийн санхүүгийн зах зээлээс эх үүсвэр татах боломж хумигдах тохиолдолд Монгол улсын эдийн засгийн өсөлт саарч, 2022 онд ердөө 0.7 хувь болж болзошгүй байна” гэж дүгнэжээ. Олон улсын санхүүгийн байгууллагууд манай эдийн засгийн өсөлтийг өмнө нь 4-6 хувь гэж тооцож байсан төсөөлөл ийнхүү огцом өөрчлөгджээ.

Монгол Банк гаргадаг статистик үзүүлэлтээр Монгол Улсын нийт гадаад өр 2021 оны IV улирлын байдлаар 33 тэрбум 805 сая ам.доллар буюу 106.5 их наяд төгрөгт хүрчээ. Монгол улсын гадаад өр олон улсын дундаж, зохистой хэмжээтэй харьцуулахад 5 дахин өндөр байгааг Олон Улсын Валютын Сан анхааруулж байсан. Дэлхийн банк “Монгол улс хойч үедээ өр өвлүүлж байна” гэж дүгнэж байв. Дэлхийн Банкнаас 2022 оны 4 сард гаргасан тайланд Монгол улсын Засгийн газрын өр 2021 онд ДНБ-ий 81 хувьд хүрсэн ба Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн үлдэгдэл болох 1.8 тэрбум ам.долларыг оруулан тооцвол Засгийн газрын өр ДНБ-ий 92 хувьд хүрэхээр байна гэжээ.

Гадаадад төлөх өрийн төлбөр улсын хатуу валютын нөөцийг шавхаж, бүхэлдээ эдийн засагт чөдөр тушаа болдог. Зээлийн төлбөрийг дахин зээл авч

санхүүжүүлэх нь ирээдүйн орлогоосоо хумсалж байгаа нэг хэлбэр. Өөрөөр хэлбэл, ирээдүй хойч үеэз эдийн засгийн өсөлтөөс хуртэх боломжийг хязгаарлаж байгаа явдал юм. Монгол улсад ойрын ирээдүйд “өрийн хавх”-аас мултрах нэн хүнд зорилт хүлээж байгаа тул төрийн элдэв маргаанаа орхин экспортын бодлогодоо нэн яаралтай шинэчлэл хийх шаардлага тавигдаж байна.

Далайд гарцгүй Монгол Улсын хувьд хөрш орнууддаа, цаашлаад тэдгээрээр дамжин далайд хүрч гуравдагч улсуудад бараа, бүтээгдэхүүнээ ашигтай нөхцөлөөр экспортлохын тулд зөвхөн төмөр замын дотоодын оновчтой зохион байгуулалт бүхий нэгдсэн сүлжээтэй болох, төмөр замаар хөрш улсуудын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын бүтээн байгуулалт хийсний үр дүнд экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар өнөөдөр ашиглаж буйгаас 3.5 дахин нэмэгдэх тойм тооцоо байна.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, санаачлан боловсруулсан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү УИХ-ын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшилаагүй нийцэж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь дэлхий нийтийг хамарсан цар тахал болон бусад геополитик, эдийн засгийн хямрал нүүрлэсэн өнөө үед хүнээс хамаарал багатай их хэмжээний тээвэр хийх боломжийг гаргаснаар экспортын орлого нэмэгдэнэ

ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БҮЙ УЧИР ШАЛТГААН

Монгол улсын эдийн засаг 2020 онд 5.3 хувиар огцом буурч, 2021 онд дөнгөж 1.4 хувь өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, манай улсын эдийн засаг сүүлийн хоёр жил агшжээ. Энэ оны эхны улиралын дүн ч нэн тааруу буюу хасах 3.8 хувьтай гарчээ. Инфляц буюу үнийн өсөлт 15 хувь хүрсэн нь Ази тивдээ Шри-Ланкийн дараа орох үзүүлэлт юм. Эдийн засаг нь агшаад зогсохгүй өндөр инфляцтai давхцах үзэгдлийг эдийн засагт стагфляц гэдэг. Тэгвэл Монгол улс стагфляцид нэрвэгдээд зогсохгүй нэмээд өрийн хямралд өртжээ. Ийм гурвалсан хямралыг даван туулах туйлын хүнд. Манай улс 3.4 сая хүн амтай, ДНБ нь ердөө 13 тэрбум ам.доллар хэрнээ нийт өр 33 тэрбум ам.доллар давжээ. Энэ нь нэг хүнд оногдох өрийн хэмжээгээр дэлхийд тэргүүлэх үзүүлэлт юм.

Гадаад орчны дарамт өндөр, гадаад орчноос шалтгаалах эрсдэл нэмэгдэж байна. Хойд хөрш НҮБ-ын гишүүн Украина улс руу халдан довтолсноор дэлхийн улс орнуудын хорионд орж эдийн засаг нь 8 хувиар буурах магадлалтай байгаа талаар олон улсын санхүүгийн байгууллагууд анхааруулж байна. Урд хөрш “тэг ковид” гэх нэн хатуу бодлого хэрэгжүүлж байгаатай холбоотой эдийн засаг нь саарах төлөвтэй байна. АНУ бодлогын хүүгээ өсгөж байгаа нь валютын урсгал хөгжиж буй орнуудаас гарах хандлага ажиглагдаж эхэллээ. Ийнхүү манай хоёр хөрш төдийгүй дэлхийн эдийн засгийг тодорхойлогч гүрнүүдийн хэрэгжүүлж буй бодлого Монгол улсын хувьд ойрын хугацаанд нэн таагүй байх нь.

Монгол улсын эдийн засгийн бүтэц нь уул уурхайгаас хараат байна. Энэ байдал ойрын жилүүдэд өөрчлөгдөхгүй. Эдийн засгаа солонгоруулахын тулд бусад салбарт оруулах хөрөнгө оруулалт чухал юм. Ийм боломжийг Монгол улсын экспортын бүтээгдэхүүнийг бага зардлаар уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа энэ цаг хугацаанд хийх ёстой юм. Иймээс төмөр замын шинэ шугам баригдаж ашиглалтад орсноор төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй систем бүрдэж эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн хамт дамжин өнгөрөх тээвэр илүү хөгжих нөхцөл бүрдэх юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол улсын эдийн засаг уул уурхайгаас хараат бөгөөд Ковидын өнгөрсөн хоёр жилийн хүндрэл, ОХУ болон Украина хоорондын дайн, дэлхийн тэргүүлэх чиглэлийн орнуудын ковидын дараах төсөв, мөнгөний бодлого эрс өөрчлөгдсөнтэй холбоотой манай улсын эдийн засагт ирж буй хүндрэлүүдийг даван туулахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлага үүсээд байна.

Иймд уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд төмөр замын тээн нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Далайд гарцгүй Монгол Улсын хувьд хөрш орнууддаа, цаашлаад тэдгээрээр дамжин далайд хүрч гуравдагч улсуудад бараа, бүтээгдэхүүнээ ашигтай нөхцөлөөр экспортлохын тулд зөвхөн төмөр замын дотоодын оновчтой зохион байгуулалт бүхий нэгдсэн сүлжээтэй болохоос гадна төмөр замаар хөрш улсуудын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын бүтээн байгуулалтын дунд ОХУ болон БНХАУ-ын төмөр замуудтай холбогдох шинэ гарц нээх нэн чухал шаардлага тавигдаж байгаа юм.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-д заасан асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Төмөр замаар хөрш улсуудын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын бүтээн байгуулалт хийх хууль эрхзүйн үндэс бүрдэнэ.	Улсын төсвөөс ямар нэгэн хөрөнгө гарахгүй.
2	ҮИХ-ын төсөл боловсруулж батлуулснаар,	Үр дүнд экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар өнөөдөр ашиглаж буйгаас 3.5 дахин нэмэгдэх тойм тооцоо байна.	Гадаадын хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтыг ашиглах боломж нээгдэнэ.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг арилгахын тулд авч буй түр, тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

1.2. Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцсэн
1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцнэ
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, ээрэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, ээрэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй		энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Шаардлагагүй
3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
-------------------	---------------------	---------	---------

1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		Хил дамнасан хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаална
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

захиргааны зардлын ачаалал				
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Валютын урсгал нэмэгдсэнээр, хэрэглээний үнийн түвшин буурна.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Валютын урсгал нэмэгдсэнээр, хүний, гэр бүлийн санхүүгийн байдалд зөрэгээр нөлөөлнө.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Төмөр зам дагасан ажлын байр, худалдаа, үйлчилгээний ажлын байр нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн тоо өснө.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Төсвийн орлого өснө.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдал сайжирна.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Хөрөнгө оруулалтын нөхцөл сайжирч, зах зээлийн тогтвортой байдал нэмэгдэнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Эсрэгээрээ инфляц буурна.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Төмөр зам дагасан ажлын байр нэмэгдэнэ
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Төмөр зам, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо өснө

	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

**“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, санаачлан боловсруулсан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн /цаашид “Тогтоолын төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлзээ.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлзээ.

**ХОЁР. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал

“Зорилгод дүн шинжилгээ хийх” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ тухайн хуулийн төсөлд тавьсан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн эсэх, зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийлзээ. Мөн салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт, зөвлөгөөн хийж, тухайн асуудалтай холбоотой экспортлогч орнуудын туршлагыг судалсан болно.

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

“Практикт турших” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийг практикт турших нь тухайн хуулийн төсөл хэрэгжих боломжтой байна уу, хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн зөвшөөрч байна уу, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтын хийдэл, зөрчлийг тогтооход чухал ач холбогдолтой арга хэмжээ боловч практикт туршилт хийх нь ихээхэн хугацаа, хүн хүч, зардал шаарддаг тул тухайн хуулийн төслийн зохицуулалтад тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэх гадаадын практик жишээнээс үлгэрлэн авсан болно. Түүхий эдийн экспорт хийж улс орноо хөгжилд хүргэж чадсан улс орнуудын бодит жишээ дээр үндэслэсэн болно.

“Ойлгомжтой байдлыг шалгах” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томьёологдсон эсэхийг шалгаж тогтоосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад тогтоолын төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон тогтоолын төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

“Практикт турших” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийг практикт турших нь тухайн хуулийн төсөл хэрэгжих боломж байгаа эсэхийг тодорхойлсон болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд тогтоолын төслийг бүхэлд нь сонгон авлаа.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төсөл бүхэлдээ	Дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Тогтоолын төсөл бүхэлдээ	Ашигт малтмалын бүтээгдэхүүн экспотлож улс орнуудаа хөгжүүлж буй орнуудын туршлагыг судалсны үндсэн дээр Монгол орны нөхцөл байдалд нийцэх иэсэхийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Тогтоолын төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар ойлгомжтой байдлыг шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, тогтоолын төслийн зорилтыг хангах боломжтой байна.

Хэдийгээр төр засгаас тодорхой арга хэмжээ авч ирсэн боловч одоо ч эрдэс бүтээгдэхүүнийхээ хэмжээг нэмэгдүүлж чадахгүй байна. Иймд тогтоолын төслөөр Монгол улсын нүүрс болон бусад ашигт малтмалын ордууд ашиглалтад орсноор экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар өнөөдөр ашиглаж буйгаас 3.5 дахин нэмэгдэж зорилгodoо хүrnэ.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу ОХУ, Казахстан зэрэг орнуудын БНХАУ руу хийж буй түүхий эдийн статистик тооцоолол болон зэс, нүүрсний экспортоор улс орноо хөгжүүлж буй Чили, Перу зэрэг улсуудын туршлагыг судалсан болно. Тухайн

тогтоолын төсөл батлагдсанаар практикт хэрэгжих боломжгүй ямар нэгэн асуудал гарахгүй болно.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараахь асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад	Шаардлага хангасан.

удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

-----оОо-----

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”;
2. Төмөр замын тухай хууль;
3. Судалгаа

5.2. Дүгнэлт

Улсын Их Хурлын тогтоолын төслийн зохицуулалт нь тогтоолын төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн бусад зохицуулалтуудыг хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийллээ.

Тогтоолын төсөл нь үзэл баримтлал болон энэхүү тогтоолын төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомтой байх, бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байна.

-----оОо-----

**“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

“Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталснаар төсвөөс ямар нэгэн зардал гарагүй бөгөөд дараах ач холбогодолтой байх юм. Үүнд:

1. Ковидын дараах эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлж улс орнуудад нөлөөлж болох эдийн засгийн хямралыг даван туулна.
2. Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын төмөр замын салбарын хамтын ажиллагаа эрчимжиж уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт, тээвэрлэлтийн зардал, хугацаа хэмнэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тогтвортой өсөн нэмэгдсэнээр төсвийн орлого тогтворжиж, эдийн засагт эерэг үр дагавар үзүүлнэ.
3. Дээрх төмөр замын шинэ шугамууд баригдаж ашиглалтад орсноор төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй систем бүрдэж эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн хамт дамжин өнгөрөх тээвэр илүү хөгжих нөхцөл бүрдэнэ.
4. Төмөр замын бүтцийг дагасан хот, суурин, боловсруулах үйлдвэрүүд бий болох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдэн ажлын байр шинээр нэмэгдэж, хүн амын амьжиргааны түвшин дээшилж, амьдрах орчин, нөхцөл сайжирснаар төв рүү чиглэсэн хүн амын нүүдэл саарна.
5. Далайд гарцгүй манай улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа өргөжиж, уул уурхайн бүтээгдэхүүнийг хөрш орнууд болон гуравдагч орнуудад экспортлох боломж бүрдэнэ.
6. Дэлхий нийтийг хамарсан цар тахал болон бусад геополитик, эдийн засгийн хямрал нүүрлэсэн өнөө үед хүнээс хамаарал багатай их хэмжээний тээвэр хийх боломжийг гаргаснаар экспортын орлого нэмэгдэнэ.

-----оо-----



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бөхчүлүүны ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-30-34, Факс: 26-30-34
E-mail: purevdorj@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.06.08 № ЧИГ-03/5736

танай _____ -ны № _____ -т

Г Тогтоолын төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Коронавируст халдварт /ковид-19-/ын цар тахлаас урьчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдуулан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Иймд уг тогтоолын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу 72 цагийн дотор саналаа ирүүлнэ үү.

Хавсралт 57 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ

000352



БРОДКАСТИНГ

20/07/2022 00:01:47 00:04:39
"Королевский старейшина-10" чададаа төхөөрөмжийн цэргийн цагдааныг сэргээж, төслийн үеийн эзэнт гүйцэтгэх тайланыг цэвэртэй болгоно. Гэлэгээр заман тааралтадаа тааралтадаа ялангуяа зорилж идэвхижуулж чададаа төхөөрөмжийн цэргийн цагдааныг сэргээж, төслийн үеийн эзэнт гүйцэтгэх тайланыг цэвэртэй болгоно.

"ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАУЛАР БАРИМТЛАХ БОДЛОГО"-ЫН ХЭРЭГЖИЛТИЙТ ХАНГАХ ЗАРЛМАРГАА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

А.Ж. АЮУЛ ЭРХДОЛЫН ЗАЛДИНН ЭЗИН ХҮЧЛҮҮДҮҮЛСЭК УКАЙ НЭМЭЛҮҮЛСЭК УКАЙ ЗАСАА ДАЛЫН САЛДЫССООН ХҮЧЛҮҮЛСЭК УКАЙ

АЛДЫНГИ ТАУЛАР АВЧ ХЯРЭЖ ЖУЛГЭЭ ЗАЛАМ АВЧАА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

БАЧИНРИН ИММЭР СПОРТЫН ТУХАЙ ХУЛГАХ ХҮЧЛҮҮЛСЭК ИММЭР СПОРТЫН ТУХАЙ БАСКАЧИВЛСЭК ОРУУЛСАХ ТУХАЙ

БАСКАЧИВЛСАХ ТУХАЙ

БАСКАЧИВЛСАХ ТУХАЙ ХАЧИМДАХ ТУХАЙ

БАСКАЧИВЛСАХ ТУХАЙ БАСКАЧИВЛСАХ ТУХАЙ



Type here to search

Нийт санал (0)



12A Australia Newsdesk

Australia.pdf

Australia.pdf

talaish_1.jpg

talaish.png

Ulaanbaatar-6601...docx

26603575_14771.jpg

Show 2